



ТӨВ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/344

Зуунмод

Аймгийн өсвөрийн шигшээ багийн
зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5,65 дугаар зүйлийн 65.1.1, Биеийн Тамир, спортын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2022 онд Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийг цана, тэшүүр, дугуй, чөлөөт бөх, жу-до бөх, самбо бөх, хөл бөмбөг, хөнгөн атлетик, шатар, бокс, пауэрлифтинг, ширээний теннис, үндэсний сур гэсэн төрлүүдээр хичээллүүлсүгэй.


2. Аймгийн өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагаанд шаардагдах 15,120,000 (арван таван сая нэг зуун хорин мянган) төгрөгийн төсвийг хавсралтаар баталсугай.

3. Аймгийн өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т зөвшөөрсүгэй.

4. Аймгийн өсвөрийн шигшээ багийн сургалт дасгалжуулалтыг өндөр түвшинд зохион байгуулж, үр дүнг 12 дугаар сарын 20-ны дотор тайлагнаж ажиллахыг аймгийн Биеийн тамир, Спортын Газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Алтанхуяг), зарцуулалтын тайлан мэдээг шилэн дансанд байршуулж ажиллахыг Аймгийн Биеийн тамир, Спортын Газрын нягтлан бодогч (Б.Дугармаа) нарт үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Мөнхцэцэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

Б.Оюуншар, Санхүүжилт, [Signature]

